



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН З А Х И Р А М Ж

2018 оны 5 дугаар
сарын 4-ний өдөр

Дугаар 91

Улаанбаатар
хот

Ажлын хэсэг байгуулах тухай

1. Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-д хүн амын ажилгүйдэл, ядуурлыг бууруулах талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Дарга	-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг
Дэд дарга	-Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан
Гишүүд:	-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Б.Нямдаваа; -Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Т.Булган; -Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын дарга Г.Батхүрэл; -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Л.Мөнхзул; -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа; -Барилга, хот байгуулалтын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Батжаргал; -Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Дээд боловсролын бодлогын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Т.Амаржаргалан; -Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Р.Мэргэн; -Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Элбэгзаяа; -Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Энх-Амар;

-Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ж.Должинсүрэн;

-Үндэсний хөгжлийн газрын Судалгаа, шинжилгээний албаны дарга А.Мөнхболд;

-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын захирал М.Алтансүх;

-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн П.Хишигжаргал;

-Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Х.Ганбаатар (тохиролцсоноор);

-Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны дэд ерөнхийлөгч С.Эрдэнэбат (тохиролцсоноор).

Нарийн бичгийн
дарга:

-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэлтсийн дарга С.Дамбий;

-Үндэсний хөгжлийн газрын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга Д.Эрдэнэбаяр.

2. Ажлын хэсгээс боловсруулсан төлөвлөгөөний төслийг 2018 оны 6 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (С.Чинзориг)-т даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ